



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 464

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.3, 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн (Мэдээлэл, холбооны технологийн сургууль) албан ажлын хэрэгцээнд зориулан 1 ширхэг бага оврын автобусыг 30,000,000.00 (гучин сая) төгрөгт багтаан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр олж авахыг зөвшөөрч, худалдан авах автобусны техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал Б.Очирбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002347

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн
... 764 ... дугаар тогтоолын хавсралт



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн (Мэдээлэл, холбооны технологийн сургууль)
худалдан авах автобусны техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаар

Д/д	Автобусны техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)
1	Суудлын тоо 10, хөдөлгүүрийн багтаамж 3001 cc хүртэл, Гадаад улсад ашиглагдаж байгаад Монгол Улсад импортоор орж ирсэн бол тээврийн хэрэгслийн гэрчилгээ аваагүй байгаа автобус.	ш	1	30,000,000.00
Нийт дүн			1	30,000,000.00
				(гучин сая)